



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/18/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН 2023
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.2 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	19
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	19
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	19
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.20 № 01/38
танай _____-ны № _____-т
Өөрчлөлтгүй дүгнэлт

ТӨВ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН
ДАРГА, ХУРАНДАА С.ӨЛЗИЙБАТ
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

“Эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд мэргэжлийн манлайлал, технологийн дэвшил, цахим шилжилтэд тулгуурлан нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглүүлэн үр дүнтэй зохион байгуулах” стратеги төлөвлөгөөний зорилгыг тухай бүр нь ханган хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитаар тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

Тус байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн нэгдсэн гүйцэтгэлийг хянах, дараа жилийн төсвийн төслийг боловсруулахад ашиглах цахим системийн программ хөгжүүлэлтийн зардалд 4,000.0 мянган төгрөгийг Хууль зүй, дотоод хэргийн Сайдын 2022 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/128 дугаар тушаалаар сайдын багцад хамаарах төсвийн захирагч нар үйл ажиллагаандаа

019020035

ашиглахаар шийдвэрлэсний дагуу гэрээлж, Даталанд технологи ХХК-д төлсөн байна.

Шүүхийн шийдвэр гарсан, насжилт өндөр, 27,800.0 мянган төгрөгийн “Тариат харз” ХХК-с авах авлага барагдуулаагүй, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба дээр ажиллагаа хийгдэж байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	94,988,236.35	100,471,236.56
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	457,698.49	802,348.49
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	457,698.49	802,348.49
3121	Төгрөг	457,698.49	802,348.49
31211	Төрийн сангийн харилцах	457,698.49	802,348.49
33	АВЛАГА	27,800,000.00	27,800,000.00
335	Бусад авлага	27,800,000.00	27,800,000.00
3351	Байгууллагаас авах авлага	27,800,000.00	27,800,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	66,730,537.86	71,868,888.07
351	Түүхий эд материал	17,474,333.80	22,581,405.01
35110	Тусгай зориулалттай материал	16,087,761.01	21,500,216.01
35130	Эм боох материал	1,386,572.79	1,081,189.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,884,868.00	4,364,618.00
354	Хангамжийн материал	44,371,336.06	44,922,865.06
35410	Бичиг хэргийн материал	869,496.00	833,496.00
35420	Аж ахуйн материал	8,823,420.00	12,621,120.00
35440	Түлш, шатах тослох материал	2,757,830.00	555,400.00
35460	Хүнсний материал	2,920,590.06	1,912,849.06
35470	Бусад хангамжийн материал	29,000,000.00	29,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	351,978,799.29	320,949,587.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	351,978,799.29	320,949,587.39
392	Биет хөрөнгө	284,971,195.20	251,944,187.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	191,456,355.34	191,456,355.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	-80,385,329.00	-103,488,174.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	125,114,083.33	102,374,083.33
39204	Хуримтлагдсан элэгдэл	-83,920,313.92	-48,601,785.95
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	254,203,750.34	231,537,582.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	-139,829,005.75	-140,221,102.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,006,264.23	20,293,135.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,369,883.81	-5,951,230.29
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	4,246,324.00	4,246,324.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,468,500.00	1,073,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,019,549.56	-774,499.68
393	Биет бус хөрөнгө	67,007,604.09	69,005,400.00
39301	Програм хангамж	4,070,192.31	2,030,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,037,588.22	0.00
39303	Бусад биет бус хөрөнгө	66,975,000.00	66,975,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	446,967,035.64	421,420,823.95
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	410,900.00	755,550.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	410,900.00	755,550.00
413	Өглөг	410,900.00	755,550.00
4136	Бусад өглөг	410,900.00	755,550.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	410,900.00	755,550.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	446,556,135.64	420,665,273.95
51	Засгийн газрын хувь оролцоо	446,556,135.64	420,665,273.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	231,880,081.77	231,880,081.77
51101	Өмч: - төрийн	231,880,081.77	231,880,081.77
512	Хуримтлагдсан үр дүн	-32,505,368.00	-58,396,229.69
51210	Өмнөх үеийн үр дүн	-45,283,948.81	-32,505,368.00
51220	Тайлант үеийн үр дүн	12,778,580.81	-25,890,861.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	247,181,421.87	247,181,421.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	446,967,035.64	421,420,823.95

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	891,217,714.51	1,479,190,655.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,512,068.51	43,084,955.00
120	Нийтлэг татварын бус орлого	81,512,068.51	43,084,955.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	81,512,068.51	43,084,955.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	214,000.00	273,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	81,298,068.51	42,811,955.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	809,705,646.00	1,436,105,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	764,234,500.00	1,415,105,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	764,234,500.00	1,415,105,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,471,146.00	21,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,479,426.00	18,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,991,720.00	3,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	878,439,133.70	1,505,081,516.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	878,439,133.70	1,505,081,516.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	876,388,255.02	1,238,960,003.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	573,379,546.96	917,646,900.00
210101	Үндсэн цалин	378,083,530.92	557,346,676.57
210102	Нэмэгдэл	172,486,608.04	268,375,691.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,977,196.20	44,198,712.85
210104	Урамшуулал	12,832,211.80	47,725,819.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,671,069.28	18,820,716.75
210201	Тэтгэврийн даатгал	241,804.30	388,919.18
210202	Тэтгэмжийн даатгал	19,209.82	45,755.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,012.26	36,604.16
210204	Ажилгүйдлийн даатгал	4,802.44	9,151.04
210205	Эрүүл мэндийн даатгал	11,381,240.46	18,340,287.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,418,077.03	106,496,769.77
210301	Гэрэл, цахилгаан	13,061,344.03	22,617,309.57
210302	Түлш, халаалт	53,138,624.00	62,579,916.20
210303	Цэвэр, бохир ус	21,218,109.00	21,299,544.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,865,605.00	26,191,980.00
210401	Бичиг хэрэг	5,127,095.00	4,423,200.00
210402	Тээвэр, шатахуун	14,575,970.00	18,376,330.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,025,100.00	1,730,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	614,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,657,440.00	1,047,650.00
2105	Нормативт зардал	53,213,205.94	71,531,624.79
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,186,723.06	3,252,983.79
210502	Хоол, хүнс	50,026,482.88	65,278,641.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	3,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,977,449.33	8,924,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	237,700.00	0.00
210604	Урсгал засвар	23,739,749.33	8,924,600.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	216,000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	216,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,015,928.00	8,511,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,497,800.00	2,538,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	308,900.00	720,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,128.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,900.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	840,500.00	4,840,500.00
210807	Газрын төлбөр	146,700.00	146,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,847,373.48	80,619,611.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,827,020.00	3,600,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	246,100.00	246,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	79,774,253.48	76,773,511.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,050,878.68	266,121,513.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	420,000.00	265,713,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	265,293,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	420,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,630,878.68	349,013.48
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,630,878.68	349,013.48
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	59,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	59,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	12,778,580.81	-25,890,861.69
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	12,778,580.81	-25,890,861.69

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	814,206,766.00	1,445,271,450.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,501,120.00	9,165,750.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,501,120.00	9,165,750.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,501,120.00	9,165,750.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,501,120.00	9,165,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	809,705,646.00	1,436,105,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	764,234,500.00	1,415,105,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	764,234,500.00	1,415,105,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,471,146.00	21,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,479,426.00	18,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,991,720.00	3,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	801,404,746.00	1,440,926,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	801,404,746.00	1,440,926,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	799,353,867.32	1,174,805,286.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	573,362,747.01	917,646,900.00
210101	Үндсэн цалин	378,066,730.97	557,346,676.57
210102	Нэмэгдэл	172,486,608.04	268,375,691.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,977,196.20	44,198,712.85
210104	Урамшуулал	12,832,211.80	47,725,819.40

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,671,069.28	18,820,716.75
210201	Тэтгэврийн даатгал	241,804.30	388,919.18
210202	Тэтгэмжийн даатгал	19,209.82	45,755.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,012.26	36,604.16
210204	Ажилгүйдлийн даатгал	4,802.44	9,151.04
210205	Эрүүл мэндийн даатгал	11,381,240.46	18,340,287.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,418,077.03	106,496,769.77
210301	Гэрэл, цахилгаан	13,061,344.03	22,617,309.57
210302	Түлц, халаалт	53,138,624.00	62,579,916.20
210303	Цэвэр, бохир ус	21,218,109.00	21,299,544.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,899,500.00	26,545,100.00
210401	Бичиг хэрэг	4,593,200.00	4,298,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,273,800.00	15,702,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,025,100.00	1,730,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	614,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	527,400.00	4,199,400.00
2105	Нормативт зардал	51,039,700.00	70,106,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,715,800.00	2,835,600.00
210502	Хоол, хүнс	48,323,900.00	64,270,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	3,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,544,626.00	14,067,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	4,905,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	237,700.00	237,700.00
210604	Урсгал засвар	22,306,926.00	8,924,600.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	216,000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	216,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,445,028.00	17,059,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	6,926,900.00	11,086,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	308,900.00	720,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,128.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,900.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	840,500.00	4,840,500.00
210807	Газрын төлбөр	146,700.00	146,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,973,120.00	3,846,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,727,020.00	3,600,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	246,100.00	246,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,050,878.68	266,121,513.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	420,000.00	265,713,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	265,293,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	420,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,630,878.68	349,013.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,630,878.68	349,013.48
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	59,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	59,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,802,020.00	4,344,650.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,944,000.00	4,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,944,000.00	4,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,944,000.00	4,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,944,000.00	4,000,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-141,980.00	344,650.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	599,678.49	457,698.49
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	457,698.49	802,348.49

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	231,880,081.77	247,308,541.75	-45,411,068.69		433,777,554.83
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	231,880,081.77	247,308,541.75	-45,411,068.69	0.00	433,777,554.83
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00		0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00		0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
C07	Тайланг үеийн үр дүн			12,778,580.81		12,778,580.81
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	231,880,081.77	247,308,541.75	-32,632,487.88	0.00	446,556,135.64
D01	2023 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	231,880,081.77	247,308,541.75	-32,632,487.88	0.00	446,556,135.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	231,880,081.77	247,308,541.75	-32,632,487.88	0.00	446,556,135.64
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,	0.00	0.00	0.00		0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00		0.00
D08	Тайланг үеийн үр дүн			-25,890,861.69		-25,890,861.69
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	231,880,081.77	247,308,541.75	-58,523,349.57	0.00	420,665,273.95

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,471,146.00	21,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45,471,146.00	21,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,471,146.00	21,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,500,000.00	10,948,400.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	2,784,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,500,000.00	4,492,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	3,672,000.00
2105	Нормативт зардал	0.00	3,335,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	335,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	3,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,741,126.00	6,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	4,905,000.00
210604	Урсгал засвар	17,741,126.00	1,595,000.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	216,000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	216,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,230,020.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,230,020.00	0.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	45,471,146.00	21,000,000.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	45,471,146.00	21,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,479,426.00	18,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,991,720.00	3,000,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,415,378,700.00	1,414,970,686.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,415,378,700.00	1,414,970,686.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,149,665,200.00	1,149,257,186.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	917,646,900.00	917,646,900.00
210101	Үндсэн цалин	518,242,000.00	557,346,676.57
210102	Нэмэгдэл	307,233,600.00	268,375,691.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,339,400.00	44,198,712.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,160,600.00	18,820,716.75
210201	Тэтгэврийн даатгал	0.00	388,919.18
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	45,755.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	36,604.16
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	9,151.04
210205	Эрүүл мэндийн даатгал	19,160,600.00	18,340,287.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,505,900.00	106,496,769.77
210301	Гэрэл, цахилгаан	22,617,700.00	22,617,309.57
210302	Түлш, халаалт	62,587,800.00	62,579,916.20
210303	Цэвэр, бохир ус	21,300,400.00	21,299,544.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,655,700.00	15,596,700.00
210401	Бичиг хэрэг	1,573,000.00	1,514,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,210,500.00	11,210,500.00
210403	Шуудан холбоо, интернетийн төлбөр	1,730,800.00	1,730,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	614,000.00	614,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	527,400.00	527,400.00
2105	Нормативт зардал	66,770,900.00	66,770,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,500,000.00	2,500,000.00
210502	Хоол, хүнс	64,270,900.00	64,270,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,567,300.00	11,567,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	7,329,600.00	7,329,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,511,800.00	8,511,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,538,600.00	2,538,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,840,500.00	4,840,500.00
210807	Газрын төлбөр	146,700.00	146,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,846,100.00	3,846,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,600,000.00	3,600,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	246,100.00	246,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	265,713,500.00	265,713,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	265,713,500.00	265,713,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	265,293,500.00	265,293,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	420,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,415,378,700.00	1,414,970,686.52
12	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ӨӨРИЙН ОРЛОГО	273,000.00	214,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	273,000.00	214,000.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,415,105,700.00	1,414,756,686.52
131001	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,415,105,700.00	1,414,756,686.52

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэрийг үндэслэн хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах, энэрэнгүй, шуурхай байх зарчмыг баримталж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-6.5-д заасан гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлдэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт тайлангаа нэгтгүүлдэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын харьяа байгууллага юм.

Тус газар нь алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр “Нэг цэгийн үйлчилгээ бүхий, төв цагдан хорих байр”-ны барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Баян эрхэт гүн” ХХК-аар бариулж байна. 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар барилгын ажлын гүйцэтгэл 82 хувьтай явагдаж байна.

Тайлангийн хугацаанд шийдвэр гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанд хяналт тавьж, анхан шатны бүртгэл судалгааг бүрэн хөтлүүлж ажилласан бөгөөд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 62.8 хувьд хүрсэн нь улсын дундаж үзүүлэлтээс 11 хувиар илүү байна.

Шийдвэр гүйцэтгэгч нар давхардсан тоогоор нийт 55 удаа сумдад ажиллаж шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан байна.

Тус газар нь 2023 онд иргэд, олон нийтийн санаа бодлыг сонсох зорилгоор 4 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан байна.

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга болон Аймгийн Засаг даргаар батлуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь “Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ”, “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ”, “Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ”, “Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ” гэсэн үндсэн 4 хэсэг, 54 зорилт, арга хэмжээнээс бүрдсэн байна.

Байгууллагын даргын 2023 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүн, төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 91.45 хувьтай “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2023 онд байгууллагын дарга 1, удирдлага санхүү аж ахуйн 7, цагдан хорих байрны 23, шийдвэр гүйцэтгэгч 10, нийт 43 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хоригдогч, хоригдлын номын сан нь “Шинжлэх ухаан, танин мэдэхүйн, урлаг, спорт”-ын нийт 1500 орчим номтой. Аж ахуй үйлчилгээний хоригдлууд давхардсан тоогоор 85 удаа номын сангийн үйлчилгээ авсан байна.

Төсөвт байгууллагад төвлөрүүлэх нийт 2,386,781.4 мянган төгрөгийн 135 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, 160,863.8 мянган төгрөгийн 15 гүйцэтгэх баримт бичиг байцаан шийтгэх ажиллагаагаар хасагдаж, 2,225,917.6 мянган төгрөгийн 120 гүйцэтгэх баримт бичгийг биелүүлэхээс 279,354.3 мянган төгрөгийн 91 гүйцэтгэх баримт бичгийг биелүүлж, гүйцэтгэх баримт бичгийн биелэлт 75.8 хувьд хүргэж ажилласан байна.

Тус газар нь ШШГЕГ-аас ирүүлсэн үүрэг чиглэлийн биелэлтийг ханган 2023 онд үндсэн цалинг 3 удаа, хоол унааны мөнгийг 1 удаа нэмэгдүүлсэн байна.

2023 оны эхэнд цалингийн зардалд 578.3 сая төгрөг батлагдсан бөгөөд жилийн эцэст 916.2 сая төгрөг болж 58.4 хувиар нэмэгдүүлсэн байна.

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд буюу хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн өөрчлөлттэй холбоотой өөрчлөлтийг нэмж тусган мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэхэд, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь ШШГЕГ-ын даргын 2020 оны 8 дугаар сарын 20-ний өдрийн А/134 дүгээр тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэж, 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 1/158 тоотой Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,546.2 мянган төгрөгөөр буюу 5.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	457.7	802.3	344.7
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Авлага	27,800.0	27,800.0	0.0
Бараа материал	66,730.5	71,868.9	5,138.4
Үндсэн хөрөнгө	351,978.8	320,949.6	-31,029.2
Нийт хөрөнгө	446,967.0	421,420.8	-25,546.2
Өр төлбөр	410.9	755.6	344.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	446,556.1	420,665.3	-25,890.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	446,967.0	421,420.8	-25,546.2

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 457.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 802.3 мянган төгрөг болж, 344.7 мянган төгрөгөөр өссөн нь цагдан хорих байранд хоригдож буй хоригдол, хоригдогч нарын нэрийн дансны үлдэгдэл 755.7 мянган төгрөг болж өссөнтэй холбоотой бөгөөд, 46.8 мянган төгрөг нь ахмадын сангийн харилцах дансны үлдэгдэл байна.

Тайлант онд бараа материал дансны эхний үлдэгдэл 66,730.5 мянган төгрөг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын нэгдсэн хангалтаас 33.0 мянган төгрөгийн тоон гарын үсэг, 31.0 мянган төгрөгийн ном, 25.2 мянган төгрөгийн “Өчил” сэтгүүл, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанаас 139.9 мянган төгрөгийн хар тамхи илрүүлэх тест, Хорих ял эдлүүлэх албанаас 367.6 мянган төгрөгийн камер, Магнай трейд ХХК-аас 471.0 мянган төгрөгийн шатахууны урамшуулал авсан зэргийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, улсын төсвийн хөрөнгөөр 108,695.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 104,623.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, жилийн эцсийн байдлаар 71,868.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болж 5,138.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 351,978.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 320,949.6 мянган төгрөг болж, 31,029.2 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай” 731 дүгээр тогтоолын дагуу 79,472.0 мянган төгрөгийн 60 ширхэг хөрөнгийг данснаас хасаж, 39,744.3 мянган төгрөгөөр үнэлж дансанд бүртгэсэн, мөн газрын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 825 дугаар тогтоолын дагуу 22,826.4 мянган төгрөгийн 135 ширхэг хөрөнгийг акталж данснаас хассан, тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 76,773.5 мянган төгрөг байгаа зэрэгтэй холбоотой байна.

Мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор 2,000.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер шилжүүлэн хүлээж авч, төсвийн хөрөнгөөр 4,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Тайлант онд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 410.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 755.6 мянган төгрөг болж тус газрын цагдан хорих байранд хоригдож байгаа хоригдол, хоригдогч нарын нэрийн дансны үлдэгдэлтэй холбоотой 344.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 420,665.3 мянган төгрөг болж 25,890.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,055,524.0 мянган төгрөг, нийт зарлагыг 1,055,524.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт хүргүүлсэн байна. Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 314,571.6 мянган төгрөгөөр бууруулж, 2023 оны урсгал зардлын төсвийг 740,952.4 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны батлагдсан төсөв 740,952.4 мянган төгрөгийг 674,426.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,415,378.7 мянган төгрөгөөр тодотгол хийгдсэн байна.

Энэ нь 2023 онд албан хаагчдын цалин 3 удаа 339,283.0 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой зардал 22,086.9 мянган төгрөгөөр, хоолны зардал 28,270.9 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 265,293.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой өссөн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэл хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэх 1,415,378.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 408.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,414,970.7 мянган төгрөг байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70705- Шүүхийн шийдвэр гүйцэтгэл 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	1,138,622.7	1,138,273.7	349.0	99.97
2	70705- Шүүхийн шийдвэр гүйцэтгэл 80102- Туслах үйл ажиллагааны зардал	273.0	214.0	59.0	78.3
3	70705- Шүүхийн шийдвэр гүйцэтгэл 80220- Холбооны суваг ашигласны хөлс	1,738.6	1,738.6	0	100.0
4	70705- Шүүхийн шийдвэр гүйцэтгэл 80229- Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээний зардал	9,030.9	9,030.9	0	100.0
5	70705- Шүүхийн шийдвэр гүйцэтгэл 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэгийн зардал	265,713.5	265,713.5	0	100.0
	Дүн	1,415,378.7	1,414,970.7	408.0	99.97

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/14 дугаар тушаалаар “Шилдэг ногоон байгууламж, тохижилттой Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар” 1-р байр эзэлж 3,000.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-ын 2023 оны 5 дугаар сарын 10-ны

өдрийн 11 дүгээр тогтоолоор 1,000.0 мянган төгрөг, Зуунмод сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 17,000.0 мянган төгрөг, бүгд 21,000.0 мянган төгрөгийн орлого орж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд болон хамт олны биеийн тамирын хувцас жигдрэлтэд бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зардлын зарцуулалтыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт нэг хөтөлбөрийн хоёр арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт / мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70705-Шүүхийн шийдвэр гүйцэтгэл	2023.01.01-2023.12.31	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг хэрэгжүүлэх	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг хэрэгжүүлэх хөтөлбөр 99.9 %	1,415,378.7	1,414,970.7

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл /70705/ хөтөлбөрийг 99,97 %-иар хэрэгжүүлж ажилласан байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/274 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөө” батлагдаж, төлөвлөгөөний дагуу Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 19-ны А/16 дугаар тушаалаар 5 гишүүнтэй “Үнэлгээний хороо” байгуулагдаж төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 9,773.8 мянган төгрөгийн тээвэр шатахууныг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 заасны дагуу “шууд худалдан авалт” хийхээр Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 1/128 дугаар үнийн санал ирүүлэх тухай албан бичгийг 3 шатахуун түгээх станцуудад хүргүүлсэн бөгөөд заасан хугацаанд “Магнай трейд” ХХК ирүүлж, 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдөр үнэлгээний хороо хуралдаж “Магнай трейд” ХХК -г шалгаруулж гэрээ байгуулсан, 36,000.0 мянган төгрөгийн хоол, хүнсний материалын худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу “Харьцуулалтын арга”-р тендер зарлаж үнэлгээний хороо 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр тендерийн баримт бичгийг боловсруулан, багц1-мах махан бүтээгдэхүүн нийлүүлэх, багц2-бусад хүнсний материал нийлүүлэх 2 багцтай тендер зарлаж, 2023 оны 02 дугаар сарын 06, 04 дүгээр сарын 04-ний өдрүүдэд цахим тендерийг нээж, багц1-т “Мандухай цэцэн” ХХК, багц2-т “Мөнх цорж” ХХК-тай гэрээ байгуулах эрх олгож, хамтран ажиллаж, худалдан авах ажиллагааг зохих журмын дагуу хийсэн байна

Тайлант онд тус газрын Нэг цэгийн үйлчилгээ бүхий төв цагдан хорих байрны барилгын ажил 82 хувьтай явагдаж байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/158 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны төсвийн төлөвлөгөөний нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны батлагдсан төсвийн нийт зарлага 1,415,319.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 21,229.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 15,922.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллага тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 24, зарлагын 13 мөнгөн гүйлгээг болон Тендер шалгаруулсан худалдан авах ажиллагааны 3 мэдээллийг хугацаандаа бүрэн байршуулж, хуулийг хэрэгжүүлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 2 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 1/783 тоотгоор ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0.0	0	0.0	0
Албан шаардлага	2	33,737.2	2	33,737.2	100
Зөвлөмж	1	27,800.0	1	27,800.0	100
Нийт дүн	3	61,537.2	3	61,537.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудлаар төсвийн нэгдсэн системийн программ хангамжийн байнгын ажиллагаа, хөгжүүлэлт, төсвийн гүйцэтгэлд хяналт хийж, төсвийн төслийг боловсруулахад хэрхэн ашиглаж, үр дүн гаргаж байгаа байдлыг тодорхойлж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 59.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад 59.0 мянган төгрөгийн алдааг залруулж, хөрөнгийн тооллоготой холбоотой 1 зөрчил²д дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд туслах үйл ажиллагааны орлогоос татан төвлөрүүлсэн 59.0 мянган төгрөгийг тохируулга хийгээгүй тайлагнасан алдаа илэрснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу аудитын явцад залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Төлөвлөлт, хяналт, удирдлагыг сайжруулахтай холбоотой асуудал***

1.1. Илрүүлэлт:

Төв аймаг дахь ШШГГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 тоот тушаалаар томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисст томилогдож, тооллого хийж нягтлан бодогч тооцоог бодож, актаар бүрэн баталгаажуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.-д “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана: 1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/; 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/” гэж заасан хугацаанд тооллогыг хийгээгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “тасалбар болголт”, “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төсвийн жилд нь багтаан, хуулийн хугацаанд гүйцэтгэх

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

